

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж

2.1.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын иргэн 15-34 насны залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд үйлчилнэ.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“залуучууд” гэж 15-34 насны Монгол Улсын иргэнийг;

4.1.2.”зорилтот бүлгийн залуучууд“ гэж хэвийн ажиллаж амьдрахад нийгмийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай байгаа залуучуудыг;

4.1.3."залуучуудын хөгжил" гэж залуучуудын бие бялдар, оюун санаа, сэтгэлгээ, ур чадвар, харилцаанд гарч буй ахиц өөрчлөлтийг;

4.1.4."залуучуудын оролцоо" гэж залуучуудын улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил, шийдвэр гаргах түвшинд үзэл бодлоо илэрхийлэх, оролцох үйл явцыг;

4.1.5.“залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл” гэж залуучуудын хөгжил, оролцоог дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг;

4.1.6.“залуучуудын иргэний нийгмийн байгууллага” гэж залуучуудын оролцоотой, өөрийн удирдлагын болон тэдний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагыг;

4.1.7.“сайн дурын ажил” гэж залуучууд идэвхи санаачилга, сайн дурын үндсэн дээр, ашиг олох зорилгогүйгээр нийтийн сайн сайхны төлөө явуулж байгаа хүмүүнлэгийн тусламж, үйлчилгээг;

4.1.8.“залуучууд судлал” гэж залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас сэтгэхүй, хөгжлийг судлахад чиглэсэн шинжлэх ухааны нэг салбар судлалыг;

4.1.9.“амьдрах ухааны чадвар” гэж эрүүл, аюулгүй амьдрах зан үйл, дадал хэвшилтэй, гэр бүл, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн талаар зөв зохистой мэдлэгтэй, шийдвэр гаргах болон бусад ур чадваруудыг.

5 дугаар зүйл. Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд баримтлах зарчим

5.1.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд дараах зарчмыг баримтална:

5.1.1.үндэсний эв нэгдэл, шударга ёсыг дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.2.залуучуудын хөгжлийн талаар төрийн бодлого, шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд залуучууд, тэдний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий залуучуудын иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн оролцоог хангах;

5.1.3.залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, тэдний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Нийгмийн хөгжилд оролцох залуучуудын эрх, үүрэг

6 дугаар зүйл. Нийгмийн хөгжилд оролцох залуучуудын эрх, үүрэг, эрхэмлэх зүйл

6.1.Залуучууд Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн эрх эдэлж, үүрэг хүлээхээс гадна нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтад манлайлан оролцохдоо дараах зүйлсийг эрхэмлэнэ:

6.1.1.нийгэм, эдийн засаг, соёл, спорт, урлагийн аливаа арга хэмжээнд идэвхтэй оролцож, эрүүл, чадварлаг, бүтээлч, ёс суртахуунтай, боловсролтой, соёлтой иргэн болж төлөвших, өөрийгөө хөгжүүлэх;

6.1.2.нийтийн эрх ашгийн төлөө сайн дурын ажилд оролцох;

6.1.3.хүмүүнлэгийн болон гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, сэргээн босгох үйл ажиллагаанд сайн дураар идэвхи санаачилгатай оролцох;

6.1.4.амьдрах ухааны мэдлэг, чадвар эзэмшиж, санхүүгийн мэдлэг, чадвар, сахилга баттай байх;

6.1.5.хэвлэл мэдээлэл болон цахим орчинд хэн нэгнийг санаатай болон санамсаргүйгээр гутаан доромжлохгүй байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих

7 дугаар зүйл. Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэл

7.1.Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараах чиглэлээр зохион байгуулна:

7.1.1.хувь хүний хөгжил;

7.1.2.боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан;

7.1.3.эрүүл мэнд;

7.1.4.хөдөлмөр эрхлэлт;

7.1.5.аюулгүй амьдрах, хөгжих орчин.

8 дугаар зүйл. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих

8.1.Залуучуудын хувь хүний хөгжлийг дараах чиглэлээр дэмжинэ:

8.1.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах;

8.1.2.залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих;

8.1.3.түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн хувь хүний хөгжлийг дэмжих хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг сайн дурын үндсэн дээр хамруулах;

8.1.4.залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлалт зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээлийг дэмжих;

8.1.5.Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрт залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөр тусгах.

8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

8.3.Энэ хуулийн 8.1.3-т заасан залуучуудад цэргийн мэргэжил олгох журмыг Засгийн газар батална.

9 дүгээр зүйл. Залуучуудын боловсролыг дэмжих

9.1.Залуучуудын хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшүүлэхийг дараах чиглэлээр дэмжинэ:

9.1.1.үндэсний цөөнх, шилжин суурьшигч, зорилтот бүлгийн орон нутагт ажиллаж, амьдарч байгаа залуучуудын боловсролын хэрэгцээг судалж, хэрэгцээнд суурилсан сургалтыг Боловсролын тухай хуульд заасан насан туршийн боловсролын хөтөлбөрийн дагуу эзэмшүүлэх;

9.1.2.залуучуудыг эх орондоо болон өндөр хөгжилтэй оронд мэргэжил эзэмших, мэргэших боломжийг бүрдүүлэх;

9.1.3.номын сангийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй болгох арга хэмжээ авч, цахим номын сан хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

9.1.4.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь хугацаат цэргийн алба хаасан, цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан суралцагчийн амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн кредит цагийг нөхөн тооцох.

9.2.Энэ хуулийн 9.1.1-9.1.3-т заасан хөтөлбөрийг залуучуудын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

9.3.Энэ хуулийн 9.1.4-т заасан кредит цаг нөхөн тооцох журмыг боловсролын болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

9.4.Залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас сэтгэхүй, хөгжил, тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах зорилгоор төрөөс залуучууд судлалыг дэмжиж хөгжүүлнэ.

10 дугаар зүйл. Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах

10.1.Хорт зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал, хэвшилтэй иргэн болж төлөвшүүлэх зорилгоор залуучуудын эрүүл мэндийг дараах чиглэлээр дэмжинэ:

10.1.1.оюутнуудыг харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах ажлыг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулах;

10.1.2.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын зүгээс оюутан, залуучуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах;

10.1.3.залуучуудын эрэлт, хэрэгцээнд нийцсэн цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлж, тэдэнд зөвлөгөө өгөх, тусламж, үйлчилгээ үзүүлэх;

10.1.4.залуучуудын нас, хүйс, сэтгэхүйн онцлогт тохирсон гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах;

10.1.5.биеийн тамир, спорт, бялдаржуулалт, бясалгалын төв зэрэг залуучуудын бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэх үйлчилгээг дэмжих;

10.1.6.олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын нэвтрүүлгийн бодлого, хөтөлбөрт залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хор уршгийг ойлгуулах, эрүүл, зөв амьдралын хэвшлийг төлөвшүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах.

11 дүгээр зүйл. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

11.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэх, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох, залуучуудыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, хөрвөх чадвартай, мэргэжилтэй ажилтан, санаачлагч, баялаг бүтээгч болгон хөгжүүлэхийг дараах чиглэлээр дэмжинэ:

11.1.1.оюутан, залуучуудыг хөдөлмөр эрхлэхэд зуучлах бирж, төвүүдийг орон нутгийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын дэргэд байгуулан ажиллуулж, хөдөлмөр зуучлалын үйлчилгээг хүртээмжтэй болгох;

11.1.2.залуучуудыг хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэхийг дэмжих;

11.1.3.техник, технологи, шинжлэх ухаан, инноваци, эдийн засгийн тэргүүлэх салбарт залуучуудын гарааны бизнесийг дэмжих бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх;

11.1.4.малчин залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

11.1.5.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах;

11.1.6.гадаадад ажиллаж байгаа нарийн технологи, ажлын туршлага, ур чадвар эзэмшсэн залуучууд эх орондоо эргэн ирж ажиллахыг дэмжих;

11.1.7.мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинээр мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулах;

11.1.8.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчид болон нийслэлээс хөдөө орон нутаг руу шилжин суурьшиж байгаа залуучуудыг ажлын байраар хангах, зуучлах үйлчилгээ үзүүлэх;

11.1.9.ажил олоход хүндрэлтэй болон ажил, хөдөлмөр эрхэлж байгаа боловч орлого багатай залуучуудын орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

11.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дагуу залуучуудыг ажлын байраар хангаж байгаа хувийн хэвшлийн байгууллага, ажил олгогчийг дараах чиглэлээр дэмжинэ:

11.2.1.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчдийг тухайн жилд нь мэргэжлийнх нь дагуу байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих;

11.2.2.ажилгүй залуучуудыг үйлдвэрлэл дээр сургаж, байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийн тухайн сургалтад зарцуулсан зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн олгох.

11.3.Энэ хуулийн 11.2.1-д заасан дэмжлэгийн төрөл, хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт тодорхой тусгана.

12 дугаар зүйл. Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх

12.1.Залуучуудын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр дэмжинэ:

12.1.1.орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, түрээслэх, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрийг залуучуудын болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;

12.1.2.залуу гэр бүл тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих;

12.1.3.залуучуудыг гэмт хэрэгт татагдан орохоос урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах;

12.1.4.хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулах;

12.1.5.гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлсэн залуучуудад боловсрол, мэргэжил олгох, хорих ангиас суллагдах үед ажлын байраар хангах талаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санаачилгыг дэмжих;

12.1.6.залуучуудад зориулан хууль зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

12.1.7.хөдөө, орон нутгийн бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй ажиллаж, амьдарч байгаа залуучуудыг дэмжих, алдаршуулах.

12.2.Энэ хуулийн 12.1.2-12.1.7-д заасан үйл ажиллагааг залуучуудын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

12.3.Залуучуудын өөрийгөө хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр дэмжинэ:

12.3.1.залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн, соёл, урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, хөгжлийн төв, цэцэрлэгт хүрээлэн, дэд

бүтцийг шинээр барьж байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн тэншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх;

12.3.2.бүх шатны сургууль, хуулийн этгээдээс зохион байгуулж байгаа урлаг, соёл, спортын арга хэмжээнд залуучууд оролцох, эдгээр арга хэмжээг залуучуудын зүгээс зохион байгуулахыг дэмжих;

12.3.3.түүх, соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах;

12.3.4.залуучуудын дунд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих;

12.3.5.байгаль орчныг хамгаалах ардын зан үйлийг сурталчлах, төлөвшүүлэх санаачилгыг дэмжих;

12.3.6.залуучуудын авьяас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэх, урлаг, спортын үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр үзүүлж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

12.3.7.залуучуудын, оюутны бүсийн болон улсын хэмжээний спорт, урлагийн наадмыг зохион байгуулах залуучуудын санаачилгыг дэмжих;

12.3.8.бүх шатны сургуульд суралцагсдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг залуучуудын оролцоонд тулгуурлан зохион байгуулах талаар иргэний нийгмийн байгууллагаас гаргасан санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Залуучуудын оролцоог дэмжих

13 дугаар зүйл. Нийгмийн хөгжилд залуучуудын оролцоог дэмжих

13.1.Төрөөс залуучуудын оролцооны дараах хэлбэрийг дэмжинэ:

13.1.1.залуучуудын өөрсдийн эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох, хэрэгжилтийг хамтран зохион байгуулах, биелтэлтэд нь хяналт тавих;

13.1.2.залуучуудын иргэний нийгмийн байгууллагын нийтэд тустай үйл ажиллагааг дэмжих;

13.1.3.залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих.

14 дүгээр зүйл. Залуучууд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөл үзүүлэх

14.1.Залуучуудыг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцоулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

14.1.1.эрх ашгийг нь хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож, саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх, тэднийг мэдээллээр хангах;

14.1.2.шийдвэр гаргах, нөлөөлөл үзүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд шууд болон өөрийн төлөөллийн байгууллага, хуулийн этгээдээр дамжуулан оролцох боломжийг бүрдүүлэх;

14.1.3.сайн засаглалыг хөгжүүлэх, авлигатай тэмцэх, түүнийг бууруулах үйл ажиллагаанд залуучуудыг оролцоог дэмжих.

15 дугаар зүйл. Залуучуудын байгууллага, нийтэд тустай үйл ажиллагаа, хөдөлгөөнийг дэмжих

15.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь залуучуудын иргэний нийгмийн байгууллага, нийтэд тустай үйл ажиллагаа, хөдөлгөөнийг дараах чиглэлээр дэмжинэ:

15.1.1.залуучуудыг бие даан амьдрах, нийгэм, эдийн засгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулах;

15.1.2.залуучуудын соёл, боловсрол, иргэний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

15.1.3.хүнд нөхцөлд амьдарч байгаа залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг үе тэнгийнхэн болон сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулах;

15.1.4.хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамж, халамжийн үйл ажиллагаанд сайн дурынхан, аж ахуйн нэгж, байгууллага хамтран ажиллахыг дэмжих.

16 дугаар зүйл. Хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих

16.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэ хуулийн 6.1.2, 6.1.3-т заасан сайн дурын болон хүмүүнлэгийн ажилд оролцсон залуучууд болон залуучуудын иргэний нийгмийн байгууллагын сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Залуучуудын хөгжлийг дэмжихэд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг

17 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

17.1.Улсын Их Хурал залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.төрөөс залуучуудын хөгжлийг хангах талаар баримтлах бодлогыг тодорхойлох;

17.1.2.залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлах;

17.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

17.1.4.хууль тогтоомжид заасан бусад.

18 дугаар зүйл. Засгийн газрын чиг үүрэг

18.1.Засгийн газар залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

18.1.2.залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө батлах;

18.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж, батлуулах;

18.1.4.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

18.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

19 дүгээр зүйл. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

19.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тайлагнах;

19.1.2.залуучуудын асуудал хариуцсан бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

19.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг дэмжих;

19.1.4.залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

19.1.5.залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, үнэлэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, энэ чиглэлээр ажилласан хугацааг тухайн иргэний нийт ажилласан жил, ажлын туршлагад тооцох тогтолцоог бий болгох;

19.1.6.оюутан, залуучууд цагийн ажил хийх тогтолцоог бий болгож, хэрэгжлтийг зохион байгуулах;

19.1.7.хууль тогтоомжид заасан бусад.

19.2.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

20 дугаар зүйл. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

20.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

20.1.2.орон нутгийн салбар, нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх;

20.1.3.залуучуудын асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

20.1.4.залуучуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх;

20.1.5.залуучуудын хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээдийг алдаршуулах, шагнаж, урамшуулах;

20.1.6.залуучуудын үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих;

20.1.7.залуучуудын хөгжлийн чиглэлээр хууль тогтоомжийн хүрээнд гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

20.1.8.энэ хуулийн 8.1.2, 8.1.4, 9.4, 10.1.4-т заасан чиг үүрэг, арга хэмжээг гэрээний үндсэн дээр төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

20.1.9.хууль тогтоомжид заасан бусад.

20.2.Энэ хуулийн 20.1.4-т заасан мэдээллийн санг бүрдүүлэх журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Үндэсний статистикийн хороо, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллага хамтран батална.

20.3.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутагт харьяа залуучуудын хөгжлийн төвтэй байж болно.

20.4.Энэ хуулийн 20.3-т заасан залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

20.5.Залуучуудын хөгжлийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.5.1.залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах;

20.5.2.залуучуудын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх;

20.5.3.залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих;

20.5.4.залуучуудыг эрүүл мэндийн, ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлах;

20.5.5.залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж, энэ чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;

20.5.6.зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд зуучлах.

21 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

21.1.Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.1.1.харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа залуучуудын салбар зөвлөлийг тэргүүлэх;

21.1.2.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

21.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

21.1.4.энэ хуулийн 13-16 дугаар зүйлд заасан арга хэмжээг залуучуудын оролцоог дэмжих тусгай хөтөлбөрийн дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

21.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

22 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөл

22.1.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ.

22.2.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг төрийн байгууллага, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, залуучуудын төлөөллийг оролцуулан Зөвлөлийн тэргүүн батална.

22.3.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.

22.4.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

22.4.1.залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах;

22.4.2.залуучуудын хөгжлийг дэмжих, тэдний эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд залуучууд, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, тэдгээрийн гаргасан санаачилгыг дэмжих;

22.4.3.залуучуудын хөгжлийг дэмжих асуудлаар гадаад улс, олон улсын байгууллага, ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

22.4.3.залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрэмд заасан бусад.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хуулийн биелэлтэд хяналт тавих

23 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

23.1.Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага, албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.

23.2.Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу энэ хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийнэ.

23.3.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийг зөрчсөн буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

24.1.Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, СУРАЛЦАГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2¹ дахь хэсгийг нэмсүгэй:

“10.2¹ Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн сургалтын төлбөрөөс тухайн хичээлийн жилийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцож, эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Залуучуудын хөгжлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “тусгагдсан байна.” гэсний дараа “Энэ хуулийн 8.2.6-д заасан нэвтрүүлэг нь залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийн тусгайлан тогтоосон цагийн квоттой байна.” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд дор дурдсан агуулгатай нэмэлт оруулсугай:

1/ 16 дугаар зүйлийн 16.18 дахь хэсэг:

”16.18.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь оюутан, суралцагчдад харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ